



СОЁМБОМ ЭЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№142 /356/

2022.08.15

Цаг үе, үйл явдал

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ СҮЛД ДУУТАЙ БОЛОВ



Өнгөрсөн жил түүхт 100 жилийнхээ ойг ёслол төгөлдөр тэмдэглэсэн Цэргийн төв эмнэлгийнхэн “Хос тангарагтан” хэмээх сүлд дуутай болж, өнөөдөр хүндэтгэлтэйгээр хүлээн авлаа.

Монгол Улсад шинжлэх ухааны анхны эмнэлэг болон үүсэн байгуулагдсан Цэргийн төв эмнэлгийн түүхт 101 жилийн ой өнөөдөр тохиож байгаа бөгөөд тус

эмнэлгийн дарга-ерөнхий эмч хурандаа Б.Энх-Од нийт бие бүрэлдэхүүндээ ойн баярын мэндчилгээ дэвшүүлж, ажлын амжилт хүслээ. Байлдааны тугаа залж, нэгдсэн тооллого явуулж, ёслолын жагсаал хийсний дараа Цэргийн төв эмнэлгийнхэн “Хос тангарагтан” сүлд дуугаа сонордож, уран бүтээлчдэд нь талархал илэрхийлэв.

Эх орноо хамгаалах эр цэргийн тангараг, эгэл түмнээ авран нигүүлсэх эмчийн тангарагийг хослон өргөсөн цагаан нөмрөгт цэргийн эмч нарынхаа ажил үйлс, алдар гавьяаг магтан дуулсан энэхүү сүлд дууны үгийг яруу найрагч МУСТА Ж.Ганчимэг бичиж, аяыг Монгол Улсын Урлагийн гавьяат зүтгэлтэн, хөгжмийн зохиолч Б.Магсаржав бүтээн

туурвисан юм.

Ташрамд дурдахад, ард олноо Цэргийн госпитал нэрээрээ алдаршсан Цэргийн төв эмнэлэг нь 1921 оны 8 дугаар сарын 15-нд жанжин Д.Сүхбаатарын санаачилгаар цэрэг, ардад үнэ төлбөргүй үйлчлэх “Өвчтэй хүнийг эмчлэх хороо” нэртэйгээр үүсэн байгуулагдаж байжээ.

ЦЭРГИЙН ЧУУЛГЫНХАН ОЛОН УЛСЫН НААДАМД УРАН БҮТЭЭЛЭЭ ТОЛИЛУУЛСААР БАЙНА

ЦДБЭЧ-ын уран бүтээлчид “Олон улсын цэргийн наадам”-ын “Аравт-2022” олон улсын морин цэргийн уралдаан болон “Цэргийн ралли 2022” олон улсын уралдаануудын нээлтэд оролцож, цэрэг эх орны сэдэвт уран бүтээлүүдээ толилуулж, Монгол Улсын Зэвсэгт хүчин, цаашлаад эх орныхоо сүр хүч, алдар гавьяаг гадны төлөөлөгч оролцогчид, хүндт зочдод сурталчлан таниулсаар байна.

Монгол Улсын улсад хоёр дахь жилдээ зохион байгуулагдаж байгаа “Аравт-2022” олон улсын морин цэргийн уралдаан нь олон орны морьтон залуусын авхаалж самбаа, ур чадварыг сорин, өрсөлдүүлж, морин цэргийн дайчдынхаа шандсыг сорьдог бол Увс аймагт зохион байгуулагдаж буй “Цэргийн ралли 2022” олон улсын уралдаан нь олон улсын цэргийн зориулалттай техник хэрэгсэл, машин механизмын хурд хүч, жолооч дайчдын ур чадварыг сорих томоохон сорил болдгоороо онцлогтой.



ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 23	🌧️ 11

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 28	🌧️ 23

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3.183.53	3.202.0
EUR 🇪🇺	3.283.0	3.300.0
CNY 🇨🇳	470.50	480.00
RUB 🇷🇺	42.40	57.00
JPY 🇯🇵	23.40	24.37
KRW 🇰🇷	2.32	2.49

ЗУРХАЙ



2022.08.15 /ДАВАА ГАРАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 14

ЗУНЫ АДАГ УЛААГЧИН САР НЭГ ЦАГААН МЭНГЭТЭЙ ЦАГААН ХУЛГАНА ӨДӨР

Үс засуулбал:

Эд МАЛ АРВИДНА

НАРАН УРГАХ, ШИНГЭХ:

05.42-20.13

БАРИЛДЛАГА:

Үл тохирох

ШҮТЭН БАРИЛДЛАГА:

САНСАР

Суудал: Ус

Тухайн өдөр нохой, хонь жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, туулай, морь, бич, тахиа болой. Эл өдөр насны хүч дэлгэрнэ. Эм найруулах, угаал үйлдэх, бэр авах, насны авшиг, насны бүтээл хийх зан үйл хийгээд төрөл садан бололцох, худалдаа наймааны үйлнээ сайн болой, хувцас хийх, гэр орон барих, сан нуун дарахад сайн. Зүүн нүд татвал эцэг, эх садны хэрэг бүтэх баруун нүд татвал эд олодох, зүүн чих хангинавал аймшиг болох, баруун чих хангинавал хэрүүл тэмцэл болох, хэрээ дуугарвал зочид ирэх, тагнай загатнавал сэтгэл зовох, бүх бие татвал хэрэг олон болох, хөл татвал үзэсгэлэн болно.

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 592,129,086

Эдгэрсэн

Нийт: 563,986,818

Нас барсан

Нийт: 6,444,786

"ТАКТИК, ТУСГАЙ БЭЛТГЭЛИЙН ЦОГЦОЛБОР 30-КМ"-ИЙН ЯВГАН МАРШААР ...



ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 065 ДУГААР АНГИ

"Ангийн 2021-2022 оны сургуулийн жилийн цэргийн сургалт бэлтгэлийн төлөвлөгөө" ний дагуу офицер, ахлагч нарын үүрэг гүйцэтгэх бэлэн байдлыг дээшлүүлэх, сэтгэл зүйн бэлтгэл,

бие бялдын бэлтгэлжилтийн түвшнийг нэмэгдүүлэх, алба салбаруудын харилцан ажиллагааг хангах зорилгоор "Тактик, тусгай бэлтгэлийн цогцолбор" 30 километрийн явган маршийг зохион байгууллаа.


Маршийн явцад байр зүйн баримжаалал хийх аргачлал,

тактикийн норматив 1, 2, 3 болон хордсон газар орныг туулах, химийн зэвсгээс хамгаалах 1, 2, 3а нормативыг боловсруулах хичээлүүдийг хичээлийн гурван цэгт зохион байгуулав. Түүнчлэн их амралтын үед бие бүрэлдэхүүний дунд хөгжөөнт буухиа тэмцээнийг зохион байгуулсан юм.

АЖЛЫН БАЙРНЫ АНХАН ШАТНЫ СУРГАЛТ ЯВАГДЛАА

ҮБХИС-ийг төгсөж, эх орныхоо тусгаар тогтнол, агаарын хилийн халдашгүй дархан байдал, ард иргэдийнхээ амгалан тайван байдлын төлөө зүтгэхээр тангараг өргөн тус ангид томилогдсон шинэхэн офицер, ахлагч нарыг ажил албанд нь хурдан дасгах зорилгоор "Ажлын байрны анхан шатны сургалт"-ыг долоо хоногийн хугацаанд зохион байгууллаа. Сургалтын төгсгөлд ангийн удирдлага шинэ алба хаагчдаа хүлээн авч уулзаж, "Батламж" гардуулж амжилт бүтээлийн дээдийг хүслээ.





ЖАНЖИН Д.СҮХБААТАРЫН НЭРЭМЖИТ СҮХБААТАРЫН БА БАЙЛДААНЫ ГАВЪЯАНЫ БОЛОН ХӨДӨЛМӨРИЙН ГАВЪЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНТ ҮНДЭСНИЙ БАТЛАН ХАМГААЛАХЫН ИХ СУРГУУЛЬ

2022-2023 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН НАМРЫН УЛИРЛЫН МАГИСТР ДОКТОРЫН ЭЛСЭЛТ

ЭЛСЭЛТ АВАХ ХӨТӨЛБӨР, МЭРГЭЖЛИЙН ЧИГЛЭЛ:

МАГИСТРЫН ХӨТӨЛБӨР

1. Хуурай замын цэргийн сургалт
2. Агаарын цэргийн сургалт
3. Кибер аюулгүй байдлын цэргийн сургалт
4. Батлан хамгаалах
5. Цэргийн шинжлэх ухаан
6. Аюулгүй байдал судлал
7. Төрийн удирдлага

ДОКТОРЫН ХӨТӨЛБӨР

1. Батлан хамгаалах
2. Цэргийн шинжлэх ухаан
3. Аюулгүй байдал судлал

Бүртгэл: 2022.08.15-аас 2022.09.02-ны ажлын өдрүүдэд 09.00-17.00 цагт
 ҮБХИС, хичээлийн I байр, 211 тоотод бүртгэж байна.
Шалгалт: 2022.09.06 -нд
Холбоо барих: 88286325, 86100101, 99092890
E-mail: Магистр: lubatjargal@gmail.com, Доктор: sbolortsetseg22@gmail.com